



МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 196

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 140 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Барилгын оны шилдэг аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах журам”-ын 1.6. дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1.6.Оны шилдэг аж ахуйн нэгж, байгууллагуудыг үйл ажиллагааны дараах үндсэн чиглэлээр шалгаруулна:

“1.6.1.Барилгын ажил гүйцэтгэгч (2);

1.6.1.1.барилгын угсралт (1);

1.6.1.2.инженерийн шугам сүлжээ (1).

1.6.2.барилгын материал үйлдвэрлэлийн (2);

1.6.3.хот байгуулалтын баримт бичиг, барилга байгууламжийн зураг төсөл гүйцэтгэгч (2);

1.6.4.өргөх байгууламжийн угсралт, засвар үйлчилгээний (1);

1.6.5.нийтийн аж ахуй (1);

1.6.6.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (1);

1.6.7. Гадаад улс оронд барилгын үйл ажиллагааг өргөжүүлсэн (1).

2. “Барилгын оны шилдэг аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах журам”-ын нэгдүгээр хавсралтыг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай:

“БАРИЛГЫН САЛБАРЫН ОНЫ ШИЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА
ШАЛГАРУУЛАХ БАЙНГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: -Барилга, хот байгуулалтын Дэд сайд

Гишүүд: -Барилга, хот байгуулалтын яамны Барилга, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

152301594

- Барилга, хот байгуулалтын яамны Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын газрын дарга;
- Барилга, хот байгуулалтын яамны Салбарын хяналтын газрын дарга;
- “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын захирал;
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашшиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны төлөөлөл;
- “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” ТББ-ын төлөөлөл /тохиролцсоноор/;
- “Монголын барилгачдын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо” ТББ-ын төлөөлөл /тохиролцсоноор/;
- “Өргөн тээвэрлэх машин төхөөрөмж үндэсний холбоо” ТББ-ын төлөөлөл /тохиролцсоноор/;
- “Монголын барилгын инженерүүдийн холбоо” ТББ-ын төлөөлөл /тохиролцсоноор/;
- “Монголын архитекторуудын эвлэл” ТББ-ын төлөөлөл /тохиролцсоноор/;
- “Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-ын төлөөлөл /тохиролцсоноор/;
- “Барилгын зураг төсөл зохиогчдын холбоо” ТББ-ын төлөөлөл /тохиролцсоноор/;
- “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-ын төлөөлөл /тохиролцсоноор/;
- “Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг” ТББ-ын төлөөлөл /тохиролцсоноор/;
- “Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо” ТББ-ын төлөөлөл /тохиролцсоноор/.


Нарийн бичгийн дарга: - Төрийн захиргааны удирдлагын газрын дарга”

3. Мөн журмын есдүгээр хавсралт болгож “Барилгын салбарын оны шилдэг аж ахуйн нэгж, байгууллагын тугны байршил”-ыг хавсралт ёсоор баталсугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэнд даалгасугай.



Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны ... дугаар сарын ...-ны
өдрийн ... дугаар тушаалын хавсралт



“Барилгын салбарын оны шилдэг аж ахуйн нэгж, байгууллагыг
шалгаруулах журам”-ын есдүгээр хавсралт

БАРИЛГЫН САЛБАРЫН ШИЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТУГНЫ БАЙРШИЛ

- Барилга угсралт
- Хот байгуулалтын баримт бичиг, барилга байгууламжийн зураг төсөл
- Барилгын материалын үйлдвэрлэл
- Нийтийн аж ахуй
- Өргөх байгууламжийн угсралт, засвар үйлчилгээ
- БХТ
- БХБЯ
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
- Инженерийн шугам сүлжээ
- Барилгын материалын үйлдвэрлэл
- Хот байгуулалтын баримт бичиг, барилга байгууламжийн зураг төсөл
- Гадаад улс оронд барилгын үйл ажиллагааг өргөжүүлсэн